



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Биеийн тамир, спорт хамтлаг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын 2006 оны "Хамтлаг байгуулах тухай" 165 дугаар захирамж, "Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм"-ийн 7.1.1, "Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын дэргэдэх орон тооны бус Биеийн тамир, спорт хамтлагийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.

2. Нийслэлийн болон байгууллагын хэмжээний тэмцээн уралдаанд оролцох баг бүрэлдэхүүнийг удирдлагаар ханган зохион байгуулах, хамтлагийн ажлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Биеийн тамир, спорт хамтлаг (Б.Амарзаяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (М.Мөнхбаяр)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2012 оны А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны ...03... дугаар сарын ..03.. өдрийн
А/..... дугаар тушаалын хавсралт

Биеийн тамир, спорт хамтлагийн бүрэлдэхүүн

Хамтлагийн ахлагч:	Б.Амарзаяа	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хөрөнгө хариуцсан ахлах зохион байгуулагч
Гишүүд:	М.Энхбаяр	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн Бүртгэлийн ахлах мэргэжилтэн
	Б.Адъяа	Өмчийн менежментийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	П.Түвшинжаргал	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Учрал	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хуулийн мэргэжилтэн
	Ц.Дашханд	Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
Хамтлагийн нарийн бичиг:	Э.Будханд	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ажилтан